



Б.Даваадорж  
ХИС-ийн НХУС-ийн Хэл зохиолын тэнхимийн багш, доктор (Ph.D)

## МОНГОЛ БИЧГИЙН ТОГТОЛЦОО

**Abstract:** Spoken language is clearly recorded in the Mongolian script which has passed through many centuries. Because Mongolian script is related to spoken language written rules have been developed in detail. Mongolian script has a detailed system distinguished by firstly letter shape, then word form and word suffixes. One lecture of Mongolian script is that it is important to clearly distinguish words on sight. A written system of Mongolian script has developed and achieved a classic form, so we should follow this tradition.

**Key words:** writing system, classic writing, roots, phonetics, homophone, homonym, difference in meaning

Хүмүүс хоорондын харилцаанд хэл чухал үүрэгтэй байдаг бол бичиг үсэг нь харилцаанд мөн адил үүрэгтэй байна. Ийм учраас хүн төрөлхтний ололт амжилтын нэгэн зүйл нь бичиг үсэг болно. Тухайн үндэстний хувьд янз бүрийн бичиг үсэг хэрэглэсэн, хэрэглэж байгаа амьдралын түүх байдаг. Улс үндэстний бичиг үсэг нь өөр өөрийн түүхтэй, өөрийн онцлогтой байна.

Дэлхийн олон үндэстний адил монголчууд олон төрөл бичиг үсгийг хэрэглэж ирсэн бөгөөд тэдгээрээс урт удаан хугацааны туршид хэрэглэгдэж байгаа бичиг нь Монгол бичиг юм. Монгол хэлний аялгууст зохицон, олон зууныг өртөөлөн, монгол үндэстний бичгийн хэлний харилцааг дотоодод бас гадаадад гүйцэтгэсээр ирсэн түүхийг нэхэн санаваас, монгол бичгийн онцлог, чадамжийг уг бичгийн тогтолцоонд хамааруулбаас зохистой буюу.

Монгол бичиг нь анхнаасаа хэрхэн хэлж ярьж байгааг тэмдэглэхэд зохилдсон агаад хэлний авианы шинж, өгүүлэхүйн онцлогийг тусган тэмдэглэх боломжийг цаашид улам боловсронгуй болгосоор сонгодог бичгийн хэмжээнд хүрсэн байна.

Авианы өгүүлэхүйн шинжийг тусгасан нь  
А. Эгшиг авиа

Монгол бичигт шүд, шилбэ, гэдэс хэмээх үндсэн зурам бий. Монгол хэлний эгшиг авиа нь эс уруулшсан (хэлний), уруулшсан хоёр янзаар өгүүлэгдэнэ. Энэ нь эгшиг авианы өгүүлэхүйн гол шинж. Энэ гол шинжийг тусгасан учир, шүд зурмаар хэлний авиаг, гэдэс зурмаар уруулын авиаг тус тус тэмдэглэдэг. Хэлний ба уруулын авиа нь чанга, хөндий байдлаар өгүүлэгдэнэ. Авианы энэ шинжийг шүд, гэдэс, шилбэ зурмаар тэмдэглэдэг. Ийнхүү тухайн үгийн бүтцэд буй авиа нь хэлний авиа байваас шүд зурмаар, уруулын авиа байваас гэдэс зурмаар, хөндий авиа байваас шилбэ зурмаар тус бүрийг ялган тэмдэглээд, харах нүднээ тодорхой болгосон байдаг.

ᠠ, ᠣ, ᠤ нь хэлний чанга эгшиг, ᠡ, ᠢ, ᠥ, ᠦ, ᠦ ᠦ нь хэлний хөндий эгшиг, ᠢ нь хэлний саармаг эгшиг (3:41) болно. Шилбэ зурмаар ийнхүү эгшгийг тэмдэглэдэг нь тухайн авианы өгүүлэхүйн шинжийг тусган улмаар хөндий буюу эм эгшгийн тэмдэглэгээ гэсэн дохио болдог. Энэ дохиолох шинж нь үг, өгүүлбэр, бичвэрийг бүхэлд нь харахад тэнд зөвхөн нэг шилбэ зурам нь онцгой дохио болж, нүднээ тусдаг. Монгол бичгийн урт хугацааны хөгжлийн явцад бичгийн тэмдэглэгээ улам боловсронгуй болсноор нэг шилбэ зурмаар хөндий эгшгийг тэмдэглэдэг нь уламжлал болсон байна. Ийм учраас үгийн бичвэрт буй нэг шилбэ зурмыг эмийн тэмдэг хэмээн хэлэлцсээр иржээ. Эмийн тэмдэг хэмээхийн учир нь аливаа үгийн бичвэрийг харахад дан ба давхар шилбэ зурмаар бичсэн байдаг. Үүний дан шилбэ зурам нь эм эгшгийн тэмдэглэгээ болдог болхулаа давхар шилбэ зурам нь ау дэвсгэр үсгийн тэмдэглэгээ болдог. Ийнхүү дан ба давхар шилбэ зурам нь эсрэгцэн үгийн дүрсийг ялган тэмдэглэж байна.

Б. Гийгүүлэгч авиа  
Монгол бичгийн үсгийн үндсэн зурам

нь шүд зурам болно. Энэхүү шүд зурмыг янз бүрээр хувирган хэлний эгшиг ба гийгүүлэгчийг тэмдэглэх тэмдэглэгээг сонгосон байдаг билээ. Хэлний гийгүүлэгч авиаг тэмдэглэхдээ эгшиг авиаг тэмдэглэсний адилаар өгүүлэхүйн шинжийг нь сайтар тусгасан байдаг.

ᠨ na, ᠮ ma, ᠯ la хэмээн тэмдэглэдэг авианууд нь өгүүлэгдэх байдал, дуурхаг шинжээрээ ойролцоо тул шүд зурмаар тэмдэглэсэн.

ᠵ ja, ᠶ ya, ᠴ ca хэмээн тэмдэглэдэг авианууд нь тагнайшиж өгүүлэгдэх тул шилбэ ба өвөрмөц эвэр зурмыг сонгосон. Бас эдгээр авиатай ойролцоо тэмдэглэгээг Re ra үсэгт оноосон байгаа нь уг авианы өгүүлэгдэх байдал зарим шинжээрээ ойролцоо болохыг харуулж байна.

ᠲ ta, ᠳ da хэмээн тэмдэглэж буй авианууд нь хэл, шүд хавсран оролцож хэлний урдуур өгүүлэгдэх тул энэхүү зурмаар тэмдэглэдэг.

ᠪ Ba, ᠶ va, ᠰ pa хэмээн тэмдэглэж буй авианууд нь уруулшин өгүүлэгдэх тул гэдэс мэт зурмыг сонгожээ.

ᠭᠠ ᠭa- ᠬᠡ ke, ᠭᠠ ᠭa- ᠬᠡ ke зурмаар тэмдэглэж буй авиа нь хэлнийх бөгөөд хэлний хойгуур өгүүлэгдэх тул тэдгээр шинжийг тусгахын зэрэгцээ эдгээр авианы дотооддоо хоёр янз өгүүлэгдэх байдлыг тодорхой тусгасан тул монгол бичгээр бичсэн үгийг шууд таньж унших боломжтой байдаг. Монгол бичигт ᠭa-ge, qa- ke үсгийн үүрэг их. Монгол бичгийн ᠭa-ge, qa-ke үсгээс бусад үсэгт эр үгэнд бичдэг зурам, эм үгэнд бичдэг зурам гэж байдаггүй. Зөвхөн эгшиг үсэгтээ түшиглэн эр, эм үгийг ялган тэмдэглэдэг. ᠭa-ge, qa- ke үсэг нь эр үг, эм үгэнд бичдэг тус тус зурамтай.

Эр үгэнд	Эм үгэнд
ᠭᠠ ᠭᠠ ᠭᠠ ᠭᠢ ᠭᠢ ᠭᠢ	ᠬᠡ ᠬᠡ ᠬᠡ ᠬᠢ ᠬᠢ ᠬᠢ
ᠭᠢ ᠭᠢ ᠭᠢ ᠭᠢ	ᠬᠢ ᠬᠢ ᠬᠢ ᠬᠢ
ᠭᠢ ᠭᠢ ᠭᠢ ᠭᠢ	ᠬᠢ ᠬᠢ ᠬᠢ ᠬᠢ

Эдгээр зурам нь үсгийн бичвэрт тодорхой байж, уншигч хүнд дохио болж байдаг. ᠭa-ge, qa- ke нь хэлний хойгуур хэлэгдэх боловч эс тагнайшин, тагнайшин хоёр байдлаар өгүүлэгддэг. Эл онцлогийг эртний үед монгол бичигт тодорхой тусгасан нь ярианы хэл, бичгийн хэлний холбоо хамаарал онцлогийг танин мэдэж, ялгаатай болоод төстэй талыг анхаарч байсны нотолгоо болж байна. ᠭa-ge, qa- ke үсгийн хувьд хэд хэдэн онцлог байна.

ᠭa-ge, qa- ke үсгээр эхэлсэн үг монгол хэлэнд олон байна.

ᠭa-ge үсэг нь урт эгшгийн нийлцэд а ᠭa, ge нийлцээр өргөн хэрэглэгддэг. Урт эгшгийн бүтэц нь үгийн дотоодод, үг бүтээх дагаварт, үг хувилгах нөхцөлд түгээмэл байдаг.

-ᠭsan/-gsen, -ᠭsaᠭar/-gseger, -ᠭtun/-gtün, -ᠭda/-gde ийм дагавруудын хэрэглээ арвин байдаг.

-qu/-kü, -ᠭ/-g, -ᠭa/-ge, -qa/-ke зэрэг дагавар, нөхцөлийн үүргээр нэлээд бичигддэг.

Ийнхүү ᠭa, qa үсгийн хэрэглээ нь бусад үсгээ бодвол илүү өргөн байна. Хэрэглээтэй уялдаж, үсгийн зурам махбод тодорхой ялгаатай байж, хамгийн гол нь тухайн үг нь чанга үг үү, хөндий үг үү гэдгийг танин, зөв уншиж ойлгоход үсгийн зурам махбодын учир холбогдол оршиж байна.

Сажа бандида Гунгаажалцан 1243 онд дөчин дөрвөн үе үсгийн цагаан толгойг журамласан (1:7) гэж тайлбарладаг. XIV зууны эхэн үед бандида Чойжи-Одсэрээс монголын 123 үсгийг (1:8) жагсаасан байдаг. Pa, ja зэрэг үсгийг нэмж тодруулсан. Ja үсгийг үгийн эхэнд бичдэг шилбэ зурмаар, үгийн дунд ба адагт бичдэг эвэр зурмаар тэмдэглэсэн байдаг. Энэ нь үсгийг зурмаар нь ондоошуулан тэмдэглэдгийг, тухайлбал, нэг үсгийн дотоодод хэрхэн ондоошуулдгийг харуулж байна. Ja үсгийг шилбэ зурмаар үгийн дунд, адагт тэмдэглэвээс Ya үсэгтэй ижилсэх тул ондоошуулаад а үсэгт ижил мэт боловч ялгаатай зурмыг сонгосон нь Ja, Ya нь монгол хэл аялгууст сэлгэдэг байсны баримт болохын хамт Ja, Ya –гийн сэлгэлт нь голдуу үгийн эхэнд тохиолдох ба тэргүүн үеэс хойш ховор мэтийг ажиглаад Ya-гаас ондоошсон, ᠴa-д төстэй зурмыг сонгосон нь Ja, ᠴa хоёр авианы өгүүлэхүйн шинжийг харгалзсан ч байж болохоор байна.

Залгавар бүтээврийг тэмдэглэсэн нь

Монгол үгийн үндэс [язгуур үг] (2:17-18)-т залгаж байгаа залгавар бүтээврүүдийг илтгэх утга, үүргийн талаас нь анхаарч тодруулан, залгаж бичих ёс бичгийн хэлний хөгжлийн явцад тогтмолжсон байна.

Монгол бичгийг хэрэглэж эхэлсэн үеэсээ эхлээд ийнхүү бичих ёсыг монгол бичиг шиг бичгээр бичдэг бусад улс үндэстний бичгийн бичих байдлаас үлгэр авсан байж болох боловч залгавар бүтээврийг, ялангуяа нөхцөлийг тухайн үгийн бүрэлдэхүүн хэсэг гэдгээр ойлгож, нөхцөлийг залгаж бичих тодорхой дэг ёс бий болон уламжлагджээ

Монгол бичигт нэр үг, үйл үгийн нөхцөлийг дагуулах ба залгах хоёр байдлаар бичдэг. Энэ бол монгол бичигт нөхцөлийг залган бичих



сонгомол арга. Нөхцөлийг дагуулах ба залгах нь нэр үг, үйл үгийн хэлбэрийг шууд оноож танин мэдэх, ойлгож ухаарахад чиглэсэн дүрсийг ялган ондоошуулсан нэгэн зүйл арга болно. Ийм учраас нэр үгийн тийн ялгал, хамаатуулахын нөхцөлүүдийг тогтмол дагуулж бичнэ. Үйл үгийн хувилган хэлбэржүүлэгч нөхцөлүүдийг шууд залган бичдэг. Нөхцөлийг дагуулах ба залгахын эсрэгцлээр нэр үг, үйл үгийн хэлбэрийг ялгаж байна.

Нэр үгийн нөхцөлийг дагуулах нь

Нэр үгийн тийн ялгалын нөхцөлүүд нь -yīn, -ūn/-ūn, -ū/-ū, -yī/-ī, -ačā/-ečē, -bār/-bēr, -iyār/-iyēr, -lu y-a/-lüge хэмээн өөртөө өргөлттэй өгүүлэгддэг учраас биеэ даасан шинжтэй байдаг. Энэ нь харьцангуй бие даасан байдлаар хэлбэржүүлж дагуулж бичих нөхцөлийг бүрдүүлдэг. Зарим тийн ялгалын dur/-dür, -tur/-tür, -tai/-tei нөхцөлүүд нь бас хэлний гийгүүлэгч авианы зохицлын онцлогийг илэрхийлж байдаг. Тухайлбал, -dur/-dür нөхцөлийг зөөлөн дэвсгэр ба эгшгээр төгссөн үгэнд, -tur/-tür нөхцөлийг хатуу дэвсгэрээр төгссөн үгэнд залгаж бичдэг уламжлалтай. Энэ нь гийгүүлэгч авианы зохицлын гол онцлогийг илэрхийлж байдаг. Монгол хэлний гийгүүлэгч авианы гол шинж нь дуутай, дуугүй шинж юм. Хэлний дуутай гийгүүлэгч авиа, дуугүй гийгүүлэгч авианы нийлэмжийг нэр үгийн өгөх оршихын тийн ялгалын нөхцөлийг дагуулах ёсноос харж болно.

Нэр үгийн хамаатуулах ёсны үндсэн нөхцөл нь -iyān/-iyēn, -ban/-ben бөгөөд хамаатуулах нөхцөл нь тийн ялгалын нөхцөлийн дараа байрладаг учраас тийн ялгалын нөхцөлтэйгөө нийлмэл хэлбэрийг бий болгодог нь -da yān/-degen, -ta yān/-tegen, -yu yān/-yügen, -ačā yān/-ečegen, -tai yān/-teyigen мэт хэлбэрүүд юм. Бас нэр үгийн үндсэнд тийн ялгалын тэг нөхцөлийн дараа iyān/-iyēn, -ban/-ben нөхцөлүүдийг бичих нь түгээмэл байдаг. Энэ нь монгол хэлний хэлэхүйн онцлогт хамаарна. Монгол хэлний нэр үгийн нөхцөлүүдийг залгах нь нэгэн зүйл тогтолцоо юм. Эл тогтолцоо ёсоор нөхцөлийг нэр үгийн үндсэнд дагуулах ёс хэлбэржин тогтжээ.

Гэвч монгол бичгийн дурсгалуудад тийн ялгалын нөхцөлүүдийг зарим тохиолдолд залгаж бичсэн нь байдаг. Энэ нь дагуулан бичихийг төдийлөн хэвшээгүй ба зарим үгэнд нөхцөлийг залган бичихэд тохиромжтой мэт санагдсан хийгээд ярианы хэлээ анхаарч тэмдэглэсэн зэрэг янз бүрийн тайлбар байж болох боловч нэр үгийн нөхцөлийг бичих тогтолцоог анхаарах нь зүйтэй. Үүнийг үл анзаарваас тогтолцоог зөрчинө. Тогтолцоог хэл “зөрчиж” болно, хүн зөрчиж болохгүй. Бичгийнхээ тогтолцоог зөрчөөд байваас бичгээ бичиг биш болгоно. Нэр үгийн нөхцөлийг дагуулах тогтолцоог зөрчсөн

мэт зүйл бий.

Нэр үгийн олны утгыг илэрхийлдэг d, -s, -čud/-čüd дагавруудыг нэр үгийн үндсэнд шууд залгаж бичдэг. Энэ нь хэлний зөрчил юм.

Үйл үгийн нөхцөлийг залгах нь

Үйл үгийг хувирган хэлбэржүүлэгч нөхцөлүүд нь :

Урт эгшгийн бүтцэд багтсан -yad/-ged, -yujai/-güjei, -yasai/-gesei мэтийн нөхцөлүүд

Давхар гийгүүлэгчээр эхэлсэн -yusan/-gsen, -yutun/-gtün, -ly-a/-lge, -ski зэрэг нөхцөлүүд

Өмнөө ямагт эгшиг (задгай үе) шаарддаг mui/-müi, -nam/-nem, -ma yča/-megeč, -y-a/-y-e гэх мэт нөхцөлүүд


Үйл үгийг хувилгагч бүх нөхцөлүүд гийгүүлэгчээр эхэлсэн байдаг. Ийм онцлогтой учраас залган бичих нөхцөлийг бүрдүүлж байна.

Үйл үгийн үндсэнд нөхцөлийг 1.Шууд залгадаг. 2.Зурмаар холбодог хоёр хэлбэр байдаг. Үйл үгийн үндэс нь задгай ба битүү үеэр төгссөн байна. Задгай үеэр төгссөн үгэнд аливаа нөхцөлийг шууд залгана. Битүү үеэр төгссөн үгэнд нөхцөлийг 1.Шууд залгана. 2.Гэдэс зурмаар холбоно. Энэ нь нөхцөлийг залган бичихийн онцлог юм.


**Утга, хэлбэрийг харгалзан бүтээврийг тэмдэглэсэн нь**

Нэр үгийн тийн ялгалын -ly-a/-lüge, үйл үгийн цагаар төгсгөхийн -ly-a/-lüge

нөхцөлүүд нь зурам, махбодоороо ижил боловч залган бичиж буй аргаараа ялгарч байдаг. Жишээлбэл:



aq-a lu-y-a, egeči-lüge, kümün-lüge, amitan -lu-y-a



yabuluy-a, irelüge, suruluy-a, nisülüge

Сэтгэхүйн үнэлэмжийн онцлогийг тусган тэмдэглэсэн байдаг. Утгын нарийн ялгааг илэрхийлэхэд da/-de, -d дагавруудыг чанар заасан тэмдэг нэрийн үндсэнд залгаж хэлэлцдэг. Жишээлбэл:

بەجە ھەبەق . بۆكەن ھەبەبەتەق .  
 بۆكەن بۆكەبەتەق ۋەبەبەن ..  
 بەجە ن ۋەبەق ن بۆكەن بۆكەبەتەق ..  
 بۆكەن بۆكەبەتەق ۋەبەبەن ..

1. Ebül bolju, edür boynidcu, söni urtudcu bayimui. Egün-i bay-a jerge urtudq-a. Čingy-a bayin-a siü suladqayarai.

بۆكەن بۆكەبەتەق ۋەبەبەن ..  
 بۆكەن بۆكەبەتەق ۋەبەبەن ..  
 بۆكەن بۆكەبەتەق ۋەبەبەن ..  
 بۆكەن بۆكەبەتەق ۋەبەبەن ..

2. Ene čamča arai tomudayad bayina. Tere ömüdü urtudažu bayin-a. Üyer bolužad youl-un usu yekedečikejükiü.

Нэгдүгээр бүлэг жишээнд зохистой хэмжээндээ байгаа ба зохистой хэмжээнд байлгах утгыг илэрхийлжээ.

Хоёрдугаар бүлэг жишээнд байх хэм хэмжээнээсээ хэтэрсэн, давсан утгыг тус тус илтгэж байна. Утгын ийм ялгааг илэрхийлэхэд –d ба –da/–de дагаврууд гол үүрэгтэй. Ийнхүү ялган тэмдэглэх ёс бичгийн хэлнээ хэвшин тогтсон байдаг.

Монгол бичигт чухам нэр үгээс үйл үг үүсгэдэг ra/–re, үйл үгээс үйл үг бүтээдэг –ra/–re, jada, quҮи мэтийн бүлэг үгээс үйл үг бүтээдэг –ra/–re дагавраар үүссэн үйл үгс нь ar дэвсгэр үсгээр төгссөн үйл үг мэт шинжтэй боловч задгай үеэр төгссөн хэлбэрээрээ өгүүлэгдэж бичигддэг. Эдгээр ra/–re дагаврууд нь монгол хэлэнд эс тусах үйл үгсийг үүсгэсэн байдаг. –ra/–re дагавраар төгссөн үгст –qa-i/–kei зэрэг нэрийн айн үгсийг бүтээх дагаврыг залгахад –ra/–re дагаврын –a/–e нь гээгддэг ёс байна. Энэ ёсоор –ra/–re дагаврын –a/–e нь дахин үг бүтээхэд ямар ч үүрэггүй бөгөөд зөвхөн –ra/–re –гийн үед үүрэгтэй байгаа нь улмаар үйл үгийн хувиллын тогтолцоонд зурам нэмэгдэх буюу гэдэс зурмаар холбодог тохиолдлыг хэт олшруулаагүй ба олшруулахаас ангижирсан хэлбэр болж байна.

Нөхцөл үйлийн –tal-a/–tele, үйл үгээс нэр үгийг бүтээх –dal/–del дагаврууд нь бүтээврийн эцэст байгаа орхиц зурмаар эсрэгцэн үгийн хэлбэрийг ялгадаг.

Жишээлбэл:

بۆكەن	بۆكەن	yabutal-a yabudal	بۆكەن	بۆكەن	güyütel-e güyüidel
بۆكەن	بۆكەن	oyutal-a oyudal	بۆكەن	بۆكەن	sayutal-a sayudal
بۆكەن	بۆكەن	bayital-a bayidal	ГЭХ МЭТ		

–tal-a/–tel-e, –dal/–del бүтээвэрт –a/–e орхиц зурам нь дүрс ялгах үүргээр бүтээврийн бүтцэд багтаж байна. Орхиц зурмыг гээж орхивоос үгийн утга эрс өөрчлөгдөн өөр утгатай үгс үүсэх болно.

Монгол бичигт үгийн тэргүүн үеэс хойш –tu/–tü орсон байваас ихэнх тохиолдолд –tu/–tü гэж –t үсгээр уншдаг. Энэ нь үгийн дунд –t үсгийг тэмдэглэх нэгэн арга болдог. Гэвч –ldu/–ldü, –Yadui/–gedüi гэсэн –d үсгээр уншдаг хэлбэр байдгийг үгүйсгэж үл болно. Монгол бичигт –Ytun/–gtün, –tuYai/–tügei, –ldu/–ldü, –Yadui/–gedüi хэлбэрээр –t ба –d –тэй нөхцөл бүтээврүүд зэрэгцэн хэрэглэгддэг боловч нөхцөл бүтээврийн утга үүрэг тодорхой бөгөөд хэрэглээ өргөн учир давтагдмал шинжээрээ таньж, будилахгүй унших бүрэн боломжтой.

Монгол бичигт зарим бүтээврүүдийг –siy-a/–siy-e ба –siya/–siye, –jan-a/–jen-e jana/–jene гэсэн хоёр хэлбэрээр бичсэн тохиолдол байдаг. Монгол бичгийн тэмдэглээний талаас нь анхаарваас зохистой билээ. Үйл үгийн хувилалд –Ya/–ge, –IYa/–lge нөхцөлүүд нь үгийн төгсгөлийн хэлбэр мэт бичигдсэн байх ба –luY-a/–lüge, –y-a/–y-e нөхцөлүүд үйл үгийн хувиллын төгсгөлийн хэлбэр болон бичигдсэн байдаг. Эдгээрээс –Ya/–qa нь угаасаа үгийн эцэст орхицтой бичигддэг учраас –Ya/–qa бүхий үеүд нь үйл үгийн хувиллын тухайн үгийн эцсийн хэлбэр мэт тохиолдолд орхиц зурамтай л бичигдэнэ.

Монгол бичгийн хэлнээ y-a/–y-e ба –n-a/–n-e зэрэг нөхцөлүүд нь үйл үгийн хувиллын эцсийн туйл болон ордог. Эдгээрийн дараа ямар нэгэн нөхцөл дахин угсран залгагдахгүй. Үйл үгийн хувиллын эцсийн туйл болон хэлбэржсэн тохиолдолд төгсгөлийн бүтээврийн бүтцэд цөөн нөхцөлд орхиц зурам байж болдог болхулаа үйл үгийн үүсмэл бус болон үүсмэл үндэс нь орхиц зурмаар бичигдэхгүй зөвхөн шүд буюу сүүл зурам бичигдэнэ. Үүнийг үйл үгийн үндэс хэлбэр ба үйл үгийн хувирсан хэлбэрийн хоорондын эсрэгцлээр тайлбарлана.



Үйл үгийн аливаа үндэс хэлбэр нь шүд буюу сүүл зурмаар бичигдэх учраас дээр дурдсан нөхцөлүүд нь –siya/-siye, -jana/- jene хэмээн шүд буюу сүүл зурмаар бичигдэнэ. Үйл үгийн аливаа үндэс хэлбэр нь шүд буюу сүүл зурмаар бичигдэх нь бүх эс үүсмэл ба үүсмэл үйл үгэнд байх тогтолцоо болно. Энэхүү тогтолцоог тодорхой учир шалтгаан, шүтэлцээгүй тохиолдолд зөрчсөн мэт хэлбэрүүдийг буй болгохоос зайлсхийвээс зохистой. Бичгийн хэлнээ тогтолцоог зөрчсөн мэт зүйл хэвшин тогтсон байж болно. Түүнийг тогтолцоонд шүтүүлэн залруулах нь зөв буюу.

Монгол бичигт qu/-kü, -qui/-küi нөхцөлүүд хэрэглэгддэг. Эдгээр нөхцөлийг үйлт нэрийн ирээдүй цагийн нөхцөл хэмээн хэлэлцээр ирсэн. Гэхдээ уламжлалт хэл шинжлэлд толь бичигт үгийг хувираагүй хэлбэр буюу үндсээр нь тэмдэглэхэд –qu/-kü –тэй бичдэг. Үйл үгийн хувирсан хэлбэрийг тэмдэглэхэд -qui/-küi нөхцөлтэйгөөр бичдэг. Энэ ёсыг монгол бичгийн хэлнээ уламжлан хэвшүүлбээс, ni-sküi ongVuča, bičiküi kičiyel, Varqui qa-YalY-a, ungsiqui nom хэмээх хэлбэрээр үйлт нэр (тодосгон холбох нөхцөл)-ээр хэлбэржүүлэх нь ийм хэлбэржилттэй үгс голдуу нэрийн айн үгстэй холбогдох тул нэр үг, нэр үгтэйгээ холбогдох үндэс үүсэж үгсийн холбоонд бичгийн хэлнээ зохистой хэлбэр болж байгаа билээ. Ийнхүү зааглан хэлэлцвээс –qu/-kü, ба -qui/-küi нөхцөлийн үүрэг хэрэглээ бодтой болох юм.

Орчин цагийн утга зохиолын хэлэнд Чамайг ирэхлээр би явъя. Барж идэхээр мэргэ ид.

Сургуульд сурахаар явна. Хийх ажлаа төлөвлөлөө. хэмээн хэлэлцдэг. Эдгээр өгүүлбэрийн утгын ялгааг нь гарган бичвээс монгол бичгийнхээ ёсонд тун нийцтэй болно. Өгүүлбэр тус тусаар авч үзвэл, Cimayi ireküler bi yabuу-a. Өгүүлбэрт явах үйл нь ирэх үйлээ дагалдаж буй учир энэ утгаар –qular/-küler нөхцөлийг монгол хэлэнд, улмаар монгол бичигт өргөн хэрэглэдэг.

Baraju idekür-emerejü ide. Энэ өгүүлбэрт хоёр ба хэд хэдэн үйлээс нэгийг нь сонгон шийдсэн утгатай байна. Ийм утгатай өгүүлбэрээр өргөн харилцдаг. Ардын аман зохиолын төрөл зүйлүүдэд ийм өгүүлбэрүүд түгээмэл байдаг. Энэ утгыг илэрхийлэн тэмдэглэхэд –qur-a/-kür-e нөхцөл хэрэгтэй буй.

SurYaYuli-dur surur-a yabumui. Энэ өгүүлбэрт зорих утга бий. Эл утгыг илэрхийлэн тэмдэглэхэд -r-a/-r-e нөхцөл үүрэгтэй. Энэ нөхцөлийг монгол бичгийн хэлнээ хэрэглэж байсан боловч орчин үед монгол бичгийн хэлнээ -r-a/-r-e бус –qu-bar/-kü-ber хэлбэрийг илүү хэрэглэсээр байгаа билээ.

Kiküi aji-l-yan tölüblelüge. хэмээн бичихэд -qui/-küi нөхцөлийг хэрэглэх нь үйлт нэрийн утга үүргийг илэрхийлэн тэмдэглэхэд илүү зохистой байдаг. Ийм байдлаар утга тус тусыг ялгаж, оноон тэмдэглэвээс монгол бичгийн тогтолцоо ёсоор тун зохистой ажгуу.

### Авианы байр, нийлэмж нь монгол бичгийн тогтолцооны суурь болох нь

Монгол бичиг нь үеийн бүтэцтэй бөгөөд үе үеэр нь холбож үгийг бүтээнэ. Бичгийн хэлний үндсэн үе нь ГЭ хэмээх бүтэцтэй байдаг. Ийм бүтэцтэй үеүд монгол бичгийн цагаан толгойд түгээмэл байна. Энэ нь гийгүүлэгч, эгшгийн байрлалыг илэрхийлнэ. Үүний зэрэгцээ ГЭГ гэсэн хэлний авианы байрлал байдаг. Энэ нь эгшиг гийгүүлэгчийн байрлалыг илэрхийлнэ. Хүний хэлэнд байгаа ГЭ, ГЭГ үеийн бүтцийг монгол бичигт тодорхой тусгасан байдаг. Эдгээр үе нь ГЭ+ГЭГ, ГЭ+ГЭ хэмээн байрлахын зэрэгцээ ГЭГ+ГЭ, ГЭГ+ГЭГ хэлбэрээр байрладаг. Энэ тохиолдолд Гийгүүлэгч+Гийгүүлэгч байрлал чухал. Үүнийг дэвсгэр үсэг хэмээх ойлголтоор тусгасан байгаа. Дэвсгэр үсгээ дотоодод нь зөөлөн дэвсгэр, хатуу дэвсгэр гэж ангилан зөв бичиж байгаа нь мөн чанараараа дуутай, дуугүй гийгүүлэгчийн байрлалыг тэмдэглэж байдаг. Хэлний гийгүүлэгч авианы дуутай, дуугүй шинж бол гийгүүлэгч авианы гол шинж. Монгол хэлний үгэнд байрлах гийгүүлэгчийн байрлал нь дуутай+дуутай, дуутай+дуугүй, дуугүй+дуугүй, дуугүй+дуутай дөрвөн хэв шинж байх ба дуутай+дуутай, дуугүй+дуугүй нийлэмж нь гийгүүлэгч авианы үндсэн нийлэмж болно. Гийгүүлэгч авианы дуутай+дуутай, дуугүй+дуугүй нийлэмжийг нэр үгийн хувилалд хувилбарт нөхцөл буюу –dur/-dür, -tur/-tür нөхцөлөөр, үйл үгийн хувилалд –ju/-jü –ču/-čü, –jaYa/-jege, –čaYa/-čege, –juqui/-jüki, –čuqui/-čüki нөхцөлөөр тэмдэглэдэг.

Монгол бичгийн үйл үгийн хувиллын бусдаар үйлдүүлэх хэвийн –Ya/-ge нөхцөл нь гийгүүлэгч авианы дуутай, дуугүйн зохицлын улмаас –qa/-ke гэсэн хувилбартай болсноор дуутай+Ya/-ge, дуугүй (d,s)+aq/-ke нийлэмжийг буй болгодог. Энэ хувилбар нь хэлэндээ байгаа бодит зүйл бөгөөд үүнийг бичигт ийм байдлаар тэмдэглэж тусгасан байна.

Гийгүүлэгч авианы нийлэмжид гийгүүлэгчийн дуутай, дуугүй шинж бас хэлний хойгуурх шинж чухал ажээ. Үүнийг монгол бичгийн хэлнээсээ харж болохоор байна. Монгол бичгийн хэлэнд n+q-k, Y-g, n= ngq, ngk, ngY, ngg, ngn гийгүүлэгчийн ийм нийлц үүсдэг. Энд ижилсэх, ондооших үзэгдэл оршиж байгаа. ngq, ngk, ngY, ngg нийлэмжид хэлний үзүүрийн n нь хэлний хойгуурх q-k, Y-g авианд ижилсэн

ng болон хувирсан ба n нь n гийгүүлэгчийн өмнө ngn болсноор ондооших үзэгдэл бий болжээ. Ийнхүү байрлалаараа ижилссэн ба ондоошсоныг монгол бичигт үйл үгийн хувилалд тодорхой тэмдэглээд бас язгуур үгийн бүтцэд эл нийлэмжийг тэмдэглэсэн байдаг.

Орчин үед монгол бичгээр хүний нэрийг бичихдээ дээр дурдсан гийгүүлэгчийн нийлэмжийг үл анзаарсан мэт буюу нийлмэл нэрийн эхний үгийн үндэс дүрсийг хадгалах зорилгоор ап дэвсгэр үсгийг хувиргалгүй бичих ёсон байгаа. Үүнийг монгол бичгийн хэрэглээтэй уялдуулан нягтлан үзвээс зохистой мэт.

**Утгын ялгамжаад дулдуйдан ижил дууг ондоошуулан тэмдэглэдэг нь**

Монгол бичгээр язгуур үгийг хэрхэн өгүүлж байгаад нь дөхүү байдлаар тэмдэглэдэг. Аливаа үгсийг бичиж тэмдэглэхэд үгийн бичлэг ижилших ба ондооших үзэгдэл бий болдог. Энэ нь бичгийн хэлнээ байх ёстой үзэгдэл.

Монгол бичигт нэр ба үйлийг заасан ижил дууг  $\text{ᠴᠢᠮᠻᠢ}$  -čimki =  $\text{ᠴᠢᠮᠻᠢ}$  --čimki-,  $\text{ᠠᠳᠴᠤ}$  adqu =  $\text{ᠠᠳᠴᠤ}$  - adqu-,  $\text{ᠪᠠᠯᠠᠭᠤ}$  balYu =  $\text{ᠪᠠᠯᠠᠭᠤ}$  -balYu-,  $\text{ᠲᠡᠪᠢᠷᠢ}$  teberi =  $\text{ᠲᠡᠪᠢᠷᠢ}$  -teberi- хэмээн ижил хэлбэрээр тэмдэглэсний зэрэгцээ  $\text{ᠴᠣᠯᠢ}$  cöl =  $\text{ᠴᠣᠯᠢ}$  - cölе-,  $\text{ᠰᠦᠷᠢ}$  sür =  $\text{ᠰᠦᠷᠢ}$  -süre,  $\text{ᠨᠠᠶᠢᠷᠠ}$  nayir =  $\text{ᠨᠠᠶᠢᠷᠠ}$  - nayira- гэж нэр ба үйлийг ялган тэмдэглэсэн нь бий. Эдгээр хос ижил дуу нь өөр хоорондоо утгын холбоотой. Утгыг холбоог илэрхийлсэн тэмдэглэгээг дурдсан жишээнээс харж болно.

Өөр хоорондоо утгын холбоогүй мэт боловч ижил дуугаар өгүүлэгдэх үгс монгол хэлэнд байх бөгөөд түүнийг бичгийн хэлнээ ялган тэмдэглэх бодит шаардлага хэлэнд байсаар байдаг. Энэ ёсоор ижил дууг ондоошуулан тэмдэглэх арга бичгийн хэлний хөгжлийн явцад боловсорсоор иржээ.

Хоёр ижил дууг ялган тэмдэглэх нь монгол бичгийн тэмдэглэгээний ижил дууг ондоошуулан тэмдэглэх эхний шат болно. Монгол хэлэнд ан ав-ав адил, дуу аялах-жуулчлан аялах, төмөр алх-хол алх, дээлийн өвөр-ар өвөр, эх эцэг-эх адаг, ооч сахал-цай ооч, унах ойчих-морь унах, уух эм-эм хонь, бэх будаг-бат бэх, малын хээл-хээл хахууль, хана хэрэм-бяцхан хэрэм хэмээн хос ижил дуунууд өөр өөр утгыг илэрхийлэх тул юуны өмнө утга өөр байваас дүрс өөр байхын ёсоор ялган тэмдэглэдэг. Жишээлбэл:

$\text{ᠠᠩ ᠪᠠ}$ Ang aba $\text{ᠠᠪ ᠠᠳᠠᠯᠢ}$ Ab adali	$\text{ᠳᠠᠶᠠᠭᠤ ᠠᠶᠠᠯᠠᠭᠤ}$ dayuu ayalqu $\text{ᠵᠢᠶᠤᠯᠴᠢᠯᠠᠨ ᠠᠶᠠᠯᠠᠭᠤ}$ jiyulcilan ayalaqu
$\text{ᠳᠡᠪᠡᠯ ᠲᠢᠨ ᠪᠦᠳᠦᠷ}$ debel-tin ebür $\text{ᠠᠷᠤ ᠥᠪᠦᠷ}$ aru öbür	$\text{ᠡᠬᠡ ᠡᠴᠢᠭᠡ}$ eke ečige $\text{ᠡᠬᠡ ᠠᠳᠠᠶ}$ eki aday
$\text{ᠠᠶᠤᠶᠠᠭᠤ ᠡᠮ}$ uuYuqu em $\text{ᠡᠮ-ᠡ ᠴᠣᠨᠢ}$ em-e qoni	$\text{ᠪᠡᠬᠡ ᠪᠣᠳᠠᠭ}$ Beke buduy $\text{ᠪᠠᠲᠤ ᠪᠡᠭᠢ}$ batu beki

$\text{ᠲᠡᠮᠦᠷ ᠠᠯᠤᠭ-ᠠ ᠴᠣᠯᠠ ᠠᠯᠠᠭᠤ}$ Temür aluq-a Qola alqu	$\text{ᠠᠨᠠᠭᠤ ᠣᠶᠢᠴᠢᠭᠤ}$ unaqu oyičiqu $\text{ᠮᠣᠷᠢ ᠠᠨᠠᠭᠤ}$ mori unuqu
$\text{ᠮᠠᠯ-ᠤᠨ ᠬᠡᠭᠡᠯ}$ mal-un kegel $\text{ᠬᠡᠭᠡᠯᠢ ᠴᠠᠭᠠᠭᠤᠯᠢ}$ kegeli qaquuli	$\text{ᠶᠠᠨ ᠠ ᠬᠡᠷᠡᠮ}$ Qan-a kerem $\text{ᠪᠢᠴᠢᠭᠠᠨ ᠬᠡᠷᠡᠮᠦ}$ Biciqan keremü

хэмээн монгол бичигт бичсэнээр энэ тохиолдолд үгийг дүрсээр нь түвэггүй ялган ойлгох боломжтой. Энэ боломжийг улам өргөжүүлэн олон ижил дууг тэмдэглэхэд ашигласан байдаг.

Монгол бичигт гурван ижил дууг ондоошуулан тэмдэглэх боломж бий. Уул нуруу-уул нутаг-хэтний уул, унтаж амар-амар хялбар-амар мэнд, шувууны үүр-үүрийн гэгээ-үүр түүр, эр хонь-хайж эр-боож эр, өл хоол-өл халзан-өл овоо, бэлэг дурсгал-бэлгэ тэмдэг-оюун билиг, хав хар-хав нохой-ид хав, хайр чулуу-хайр сэтгэл-төмрөөр хайр гэх зэрэг гурван ижил дууг

$\text{ᠠᠶᠤᠯᠠ ᠨᠢᠷᠦᠶᠤ ᠤᠯᠤ}$ ayula niruyu uul $\text{ᠨᠠᠲᠤᠶ ᠬᠡᠲᠡᠨ-ᠦ}$ nutuy keten- ü uula	$\text{ᠠᠮᠠᠷ ᠬᠢᠯᠪᠠᠷ}$ amar kilbar $\text{ᠠᠮᠤᠷ ᠮᠡᠨᠳᠦ}$ amur mendü $\text{ᠤᠨᠲᠠᠵᠤ ᠠᠮᠠᠷᠠ}$ untaju amara
$\text{ᠡᠷ-ᠡ ᠴᠣᠨᠢ}$ er-e qoni $\text{ᠴᠠᠶᠢᠵᠢ ᠡᠷᠢ}$ qayiju eri $\text{ᠪᠣᠶᠤᠵᠢ ᠡᠷᠡ}$ boYuju ere	$\text{ᠥᠯᠢ ᠴᠣᠶᠤᠯᠠ ᠥᠯᠦ}$ öl qoyula ölü $\text{ᠴᠠᠯᠵᠠᠨ ᠥᠯᠢ ᠣᠪᠤᠭ-ᠠ}$ qaljan öli obuy-a



qab qar-a  
qaba noqai  
ide qabu

qab qar-a  
qaba noqai  
ide qabu

qayur čilayu  
qayir-a sedkil  
temür-iyer qayari

qayur čilayu  
qayir-a sedkil  
temür-iyer qayari

Монгол бичигт о/у ба ö/ü эгшигтэй үгсийг ялгаж оноон уншихад бэрхшээлтэй мэт боловч тухайн уруулын авиаг монгол хэлний олон аялгууст монгол хэлний эртний үед голдуу u ба ü авиагаар өгүүлж бичигтэйгээ тохирч байжээ хэмээвээс хэлний хөгжлийн явцад хожим нь o ба ö авианууд тодорхой өгүүлэгдэн үгийн тэргүүн үеэс хойш түгээмэл ордог болсноор зарим талаар монгол бичгийн тэмдэглэгээтэй их зөрж байгаа шиг боловч уг чанартаа тохирч байдаг.

Sibayun-u egür  
ür-ün gege üür  
tütür

Sibayun-u egür  
ür-ün gege üür  
tütür

beleg durasqal  
belge temdeg  
oyun bilig

beleg durasqal  
belge temdeg  
oyun bilig

Ер монгол бичгийн тэмдэглэгээ нь хэлнийхээ тухайн үеийг сайтар тэмдэглэсэн байхаас гадна хэлний хожмын хувирал өөрчлөлттэй тохирч байдаг. Энэ бол монгол бичгийн тэмдэглэгээний онцлог, хэлнийхээ зүй тогтлыг сайтар тусгасны нутлагаа болно.

хэмээн ялган тэмдэглэдэг уламжлалтай. Гурван ижил дууг хэрхэн ондоошуулан тэмдэглэснийг анхаархулаа А ба Б, Б ба С, А ба С хос хосоороо эсрэгцэх зарчимд суурилсан байна.

Бас дөрвөн ижил дууг ялган тэмдэглэдэг. Монгол хэлэнд өөр өөр утгыг илтгэдэг асар майхан-асар тэнгэр-асар их-хүүхэд асар, хар өнгө-хар хар хийх-үзэж хара-хусаж хара, хор бодис-хор хөнөөл-хор шар-хор хор хийх, хожиж шүү-хэрэг шүү-хужир шүү-шүү дээ хэмээх үгсийг

Монгол бичгийн цагаан толгойн үгсийн тэмдэглэгээ, залгавар бүтээврүүдийг оноон тэмдэглэсэн байдал, язгуур үгийн тэмдэглэгээ зэрэг нь тодорхой тогтолцоотой байгаад улмаар монгол бичгийн тэмдэглэгээ нь давхарласан тогтолцоот шинжтэй байна. Энэ тогтолцоо нь эх хэлтэйгээ шүтэлцсэн агаад өнө удаан хугацаанд нэгэнт хэвшин тогтжээ.

asar mayiqan  
asuri tngri  
asuru yeke  
ketiked asara

asar mayiqan  
asuri tngri  
asuru yeke  
ketiked asara

qar-a öngge  
qar qar kikü  
üjeju qara  
qusuju qaru

qar-a öngge  
qar qar kikü  
üjeju qara  
qusuju qaru

### АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Лувсанвандан, Ш. (1967). *Орчин цагийн монгол хэлний бүтэц Авиа, авиалбар хоёр нь*. Нэгдүгээр дэвтэр. (7-8).

Орчин цагийн монгол хэлний үг зүйн байгуулал Тэргүүн дэвтэр. (1987). (17-18) Улаанбаатар

Пагва, Т. (1957). *“Зүрхний тольтын тайлбар”-ыг судалсан тухай тэмдэглэл*. Улаанбаатар

qour-a bodas  
qour köntügel  
qoru sir-a  
qor qor kikü

qour-a bodas  
qour köntügel  
qoru sir-a  
qor qor kikü

Qojju sügü  
Kereg sigü  
Qujir šeti  
Siü de

Qojju sügü  
Kereg sigü  
Qujir šeti  
Siü de

хэмээн ялган тэмдэглэдэг ийм боломж монгол бичигт байна. Энэ нь А ба Б, С ба D, А ба С, В ба С, А ба D, В ба D эсрэгцэлд шүтэлцэнэ.

Монгол бичигт язгуур үгсийн түвшинд хоёроос дөрвөн ижил дууг ондоошуулан тэмдэглэх боломж монгол бичгийн зурам махбодод байдаг. Ийм учраас монгол бичигт ихэнх үгсийг ялган тэмдэглэх боломжтой. Энэ боломжийг монгол бичгийн урт удаан хугацааны явцад шинэ тутам нэрлэлтээр нэмэгдсэн ижил дууг ондоошуулан тэмдэглэх арга болгосоор байсан нь монгол бичгийн тогтолцоог уламжлуулан хөгжүүлсэн шинжтэй байна.

Монгол бичигт дүрсийн ондоошлын зэрэгцээ ижилсэл байдаг. Ижилсэл нь цагаан толгойн үсэг, үг бүтээх дагавар, язгуур үгийн тэмдэглэгээнд бий. Үгсийн зурам, нэр, үйл үгийг хувирган хэлбэржүүлэх нөхцөл бүтээврүүдэд дүрсийн ижилсэл бараг байдаггүй. Ийм тогтолцоотой учраас монгол бичигт ижилсэл, ондоошлоос хамаарсан будилаан байдаггүй. Монгол бичигт язгуур үг ба хэлбэржсэн үгсийн тодорхой шинж чанар нь

- Биеэ даасан дүрсээр
- Хам сэдвийн хүрээнд тодорхой байдаг.